




ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлан



Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд иргэд, олон нийтийн сонирхсон Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэхь заалтын мэдээллүүд шаардлагын хэмжээнд мэдээлэгдээгүй байна.

2018 он

Уг тайланг WWW.AUDIT.MN сайтаас үзнэ үү.

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70463783, 70463612 дугаарын утсаар харилцана уу

ХАЯГ:
Завхан аймгийн Аудитын газар
Улиастай сум, Жинст багийн
Нутгийн захиргааны ордон
309,310 тоот өрөө

Гүйцэтгэсэн:

Ахлах аудитор
Д.Оюунжаргал
Аудитор
Б.Мөнхнасан
Д.Пүүжмаа

Хянасан:
Дарга бөгөөд Тэргүүлэх
аудитор Л.Уламбаяр

Аудитын менежер
Г.Хашцэцэг

2018.11.27

<p>Тайланг бэлтгэсэн: Завхан аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Л.Уламбаяр</p> <p>Аудитын менежер Г.Хашцэцэг</p> <p>Ахлах аудитор Д.Оюунжаргал</p> <p>Аудитор Б.Мөнхнасан Д.Пүүжмаа</p> <p>2018 оны 11 дүгээр сар Тайланг УАГ-ын веб сайт-аас үзнэ үү. www.audit.mn</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70463783, 70463612 дугаарын утсаар харилцана үү.</p> <p>Хаяг: Завхан аймаг дахь Төрийн аудитын газар Нутгийн удирдлагын ордон</p> <p>Улиастай сум Жинст баг</p>	<p>Товчилсон үгийн жагсаалт</p> <p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p> <p>Аудитын зорилт</p> <p>Аудитын хамрах хүрээ</p> <p>Арга зүй</p> <p>Аудит хийх бүрэлдэхүүн</p> <p>Зорилт 1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх</p> <p>Зорилт 2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх</p> <p>Зорилт 3. Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх</p> <p>Дүгнэлт</p> <p>Зөвлөмж</p> <p>Холбогдох байгууллагын санал</p> <p>Дарга бөгөөд тэргүүлэх аудиторын тушаал</p> <p>Хавсралтууд</p>	<p>3</p> <p>4</p> <p>4</p> <p>4</p> <p>4</p> <p>4</p> <p>5-6</p> <p>6-10</p> <p>10-11</p> <p>11-12</p> <p>12</p> <p>13-14</p> <p>15</p> <p>16</p>
--	--	---

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮАГ	Үндэсний аудитын газар
УИХ	Улсын их хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
НДС	Нийгмийн даатгалын сан
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

Аудит хийх үндэслэл

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсгийг тус тус үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2017 оны 06 дугаар тогтоол, ҮАГ-ын 2018 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг ҮАГазарт хүргүүлж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлээр аудит хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх
2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх
3. Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх

Хамарсан хүрээ:

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.3 дахь хэсэгт заасан хуулийн этгээд, төрийн байгууллагыг тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчдаас хэрэгжүүлж буй дотоод хяналтын дүн мэдээнд үндэслэн 2017 оны 10 дугаар сарын 01-нээс 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртлэх хугацааны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилийг түүвэрлэн шалгалаа.

Арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан хуулийг хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуйн нэгжийн мэдээллийн самбар болон цахим хуудаст байрлуулсан мэдээллийг дансны хуулгын дүн, анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах, хяналт хэрэгжүүлсэн байгууллагуудын тайлан, судалгаа зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулан ажиллалаа.

Аудит хийх бүрэлдэхүүн:

Аудитыг аймгийн Аудитын газрын дарга бөгөөд, Тэргүүлэх аудитор Л.Уламбаяр хянан удирдаж, аудитын менежер Г.Хашцэцэг аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналт тавьж, ҮАГ-аас ирүүлсэн төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүйг үндэслэн дэд хөтөлбөр боловсруулан багийн ахлагч аудитор Д.Оюунжаргал, аудитор Б.Мөнхнасан, Д.Пүүжмаа нар хийж гүйцэтгэлээ.

Зорилт А . Шилэн дансны цахим хуудсанд тогтмол байршуулах мэдээллүүдийг хугацаа хоцроон байршуулж байгаа дутагдал дахин давтан гарч байна

А.1 Шилэн дансны нэгдсэн сайтад хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1¹, 3.1.2², дахь заалтанд хамаарах Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй Төрийн болон Орон нутгийн өмчит 213 байгууллага, аймаг, сумын 25 төрийн сан, ОНХСан, НДС, ХЭДС, 4 төрийн өмчит үйлдвэрийн газрууд аймаг, сумдад бүртгэлтэй 14 аж ахуйн нэгж байгууллага, хувийн 2 цэцэрлэг нийт 260 байгууллагын цахим цэс Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгэгдсэн байгаагаас түүвэрлэн 251 буюу 96,5 хувьд нь аудит хийлээ .

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1³-д заасан мэдээллүүдийг хуулийн 3 зугаар зүйлийн 3.1.1, 3.1.2–т заасан судалгаанд хамрагдсан нийт 251 нэгж байгууллагуудаас:

- Тухайн жилийн төсвийг 215 байгууллага буюу 85,6 хувь нь мэдээлсэн, 23 байгууллага буюу 9,2 хувь нь мэдээлээгүй, 13 буюу 4,6 хувь нь хугацаа хоцроон мэдээлсэн,
- ХАА-ны төлөвлөгөөг хамаарал бүхий 245 байгууллагаас 207 байгууллага буюу 82,4 хувь нь мэдээлж, 24 байгууллага буюу 9,6 хувь нь мэдээлээгүй, 14 буюу 5,6 хувь нь хугацаа хоцроон мэдээлсэн
- ОНХС-гийн төлөвлөгөөг 25 төрийн сангийн 23 буюу 92 хувь мэдээлсэн, Эрдэнэхайрхан сум мэдээлээгүй, Сантмаргац сум хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2⁴-д заасан хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг 239 байгууллага буюу 95,2 хувь нь мэдээлж, 7 байгууллага буюу 2,8 хувь нь мэдээлээгүй, 5 буюу 2 хувь нь хугацаа хоцроон мэдээлсэн,

- Сар, улирлын төсвийн гүйцэтгэлийг 2017 оны 4 дүгээр улирлын байдлаар 251 нэгж байгууллагаас дунджаар 236 нь буюу 94 хувь нь мэдээлж, 2 буюу 1 хувь нь мэдээлээгүй, 13 буюу 5 хувь нь хугацаа хоцроон мэдээлсэн
- 2018 оны эхний 3 улирлын байдлаар байдлаар 251 нэгж байгууллагаас дунджаар 225 нь буюу 89,6 хувь нь мэдээлж, 4 буюу 1,6 хувь нь мэдээлээгүй, 23 буюу 8,8 хувь нь хугацаа хоцроон мэдээлсэн
- Өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг 222 нь буюу 88,4 хувь нь мэдээлж, 18 буюу 7,2 хувь нь мэдээлээгүй, 11 буюу 4,4 хувь нь хугацаа хоцроон мэдээлсэн

¹ төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

² төрийн өмчит үйлдвэрийн газар;

³ тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;

⁴ хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3⁵-д заасан дараа жилийн төсвийн төслөө 199 буюу 79,2 хувь нь мэдээлж, 32 буюу 12,7 хувь нь мэдээлээгүй, 20 буюу 8,1 хувь нь хугацаа хоцроон мэдээлсэн

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4⁶-д заасан хагас жилийн санхүүгийн тайлангаа 224 нэгж байгууллага буюу 89,2 хувь нь мэдээлж, 21 нэгж байгууллага буюу 8,4 хувь нь мэдээлээгүй, 6 буюу 2,4 хувь нь хугацаа хоцроон мэдээлсэн

- Жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 191 байгууллага буюу 76,4 хувь нь мэдээлж, 54 буюу 21,5 хувь нь мэдээлээгүй, 5 буюу 2,1 хувь нь хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5⁷-д заасан /ТЕЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор/ мэдээллийг 195 нэгж байгууллага буюу 78,3 хувь нь мэдээлж, 48 нэгж байгууллага буюу 17,9 хувь нь мэдээлээгүй, 6 буюу 3,8 хувь нь хугацаа хоцроон мэдээлсэн

- Мөн /аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор/ гэсэн мэдээллийг 201 нэгж байгууллага бүрэн буюу 80,1 хувь мэдээлсэн, 37 буюу 14,7 хувь мэдээлээгүй, 13 буюу 5,2 хувь нь хугацаа хоцроон мэдээлсэн байна.
- Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг ихэнх байгууллага бичдэггүй, зардлын зүйл ангийн хэмнэлт, хэтрэлтийн тоон үзүүлэлтийг 195 нэгж байгууллага буюу 77,4 хувь мэдээлсэн, 56 байгууллага буюу 22,6 хувь нь мэдээлээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.2⁸ дахь заалт Эрх бүхий байгууллагаас баталсан жилийн төсвийг мэдээлж, төсвийн гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт, орон нутагт төвлөрүүлэх орлого, авсан санхүүжилтээ ихэнх байгууллага мэдээлээгүй,

Хуулийн 6 дугаар зүйлин 6.3⁹-т заасны дагуу ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалтыг мэдээлж, 6.3.2- 6.3.9 хүртэлх хуулийн заалтуудыг “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3-т заасан шаардлагын хэмжээнд мэдээлээгүй, 2018 оны 4 сараас хойш аймгийн ОНХСангийн талаарх гүйцэтгэлийн мэдээллийг байршуулаагүй байна.

Мэдээллийг бүрэн байршуулаагүй шалтгааныг судлан үзэхэд зарим мэдээлэл сонголтыг буруу хийсэн, аудит болон бусад хяналт шалгалтаар өгөгдсөн зөвлөмжүүдийг

⁵ дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;

⁶ жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор;

⁷ төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор;

⁸ Энэ хуулийн 6.1.1-д заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна:

⁹ Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна:

бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, хэрэгжүүлсэн арга хэмжээ тайлбарыг мэдээлээгүй зэрэгтэй холбоотой байна гэж үзлээ.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹⁰-д заасан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн талаар 226 байгууллага буюу 90 хувь нь мэдээлж, 3 байгууллага буюу 1,2 хувь нь мэдээлээгүй, 22 буюу 8,8 хувь нь хугацаа хоцроон мэдээлсэн

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2¹¹-д заасан хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийн мэдээллийг нийт байгууллага өөрчлөлт ороогүй гэж мэдээлсэн.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3¹²-т заасан тендерийн баримт бичиг, урилга, шалгуур үзүүлэлтүүдийн талаарх мэдээллийг аймгийн Орон нутгийн өмчийн газар нь www.Тендер.gov.mn сайтад мэдээлжээ.

Аймаг 20 сая төгрөгөөс дээш тендер, худалдан авалттай холбоотой мэдээллийг Шилэн дансанд аймгийн ТЕЗ-ийн мэдээлэлд мэдээлсэн байна

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4¹³-д заасны Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт хийсэн 879,2 сая төгрөгийн, 78 гүйлгээ мэдээлэхээс 764,3 сая төгрөгийн 69 ажил гүйлгээний худалдан авалтыг мэдээлээгүй байсныг аудитын явцад цахим цэст мэдээллүүлэн ажиллаа.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5¹⁴-д заасан /цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ/ мэдээллийг түүвэрчлэн шалгахад орлогын 75 гүйлгээний 10,124.0 сая төгрөгийг мэдээлээгүй, зарлагын 69 гүйлгээний 1,574.0 сая төгрөгийн гүйлгээг мэдээлэгдэхээс 35 гүйлгээний 910.8 сая төгрөгийг мэдээлээгүй байсныг аудитын явцад цахим цэст мэдээллүүлэн ажиллаа.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.6¹⁵-д заасан хяналтыг аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын албанаас 2017 онд 50 төсөвт байгууллагад, 2018 онд 22 нэгж байгууллагад шалгалтын дүнгийн тэмдэглэл, 11 нэгж байгууллагад шалгалтын танилцууллагыг хүргүүлэн ажилласан байна.

- Шалгагдсан ТЕЗ, төсөвт байгууллагууд хяналт шалгалтын тэмдэглэл, танилцууллагыг мэдээлээгүй өөрсдийн цахим цэст байршуулаагүй зөрчил, дутагдал нийтлэг байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7¹⁶-д байгууллагын батлагдсан орон тоонд өөрчлөлт орсон эсэхийг ихэнх байгууллагууд байхгүй гэж мэдээлжээ.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8¹⁷д Төсөв, хөрөнгө зарцуулах аливаа шийдвэрийг ихэнх байгууллагууд мэдээлээгүй бөгөөд аудитын явцад аймгийн төвийн болон томилолтоор

¹⁰ тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт;

¹¹ тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт;

¹² тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;

¹³ таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;

¹⁴ цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;

¹⁵ худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн; байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт;

ажилласан 21 сумын төсөвт байгууллагаас түүвэрлэн тулгалт хийхэд 6,693.9 сая төгрөгийн 614 шийдвэрээс, 6,423.4 сая төгрөгийн 569 шийдвэрийг, 224,7 сая төгрөгийн өглөг, 57,5 сая төгрөгийн авлагыг үүссэн тухайн бүр нь байгууллагынхаа цахим цэст мэдээлээгүй зөрчлүүдийг илрүүлэн нэгж байгууллагуудын цахим хуудсанд нөхөн мэдээллүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаа .

Энэ нь хууль хэрэгжүүлж байгаа ажилтнууд Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг бүрэн хангаж ажиллахгүй байгаатай холбоотой байна гэж үзлээ.

Хуулийн 7 дугаар зүйл. Мэдээлэх албан тушаалтан гэсэн зүйлийг зөрчсөн дараах алдаа илэрлээ.

- Тодруулга өгөх албан тушаалтны нэр, гар утасны дугаар, цахим хаягийн мэдээллийг Нөмрөг, Түдэвтэй, Ургамал сумын нутгийн захиргааны байгууллага, “Очир-илч” ОНӨААТҮГазар, ЧЭЦСургууль байгууллагууд шинэчлээгүй,
- Сар, улирлын эцэст төсвийн өр, авлагатай ажилласан байгууллагууд түүний үүссэн аливаа шалтгаан, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, шийдвэрүүдийг хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлээгүй.
- Тухайлбал: Асгат, Баянтэс, Тэс, Баянхайрхан, Нөмрөг, Түдэвтэй, Алдархаан, Дөрвөлжин, Эрдэнэхайрхан, Ургамал, Завханмандал, сумдын төсөвт байгууллагууд, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Уламжлалт ангаах ухааны төв, Отгонтэнгэрийн улсын тусгай хамгаалттай газрын хамгаалтын зах иргаа, Мэргэжлийн хяналтын газар, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Татварын хэлтэс зэрэг байгууллагууд,
- Хуульд заасан хугацааг хоцроон мэдээллүүдийг байршуулсан. Тухайлбал: Аймгийн ТЕЗахирагч, Аймгийн ИТХурал, Тэс, Ургамал, Амь-ус ОНӨҮГ

A.2 Хуулийн 5 дугаар зүйлийн 5.7¹⁸ дахь хэсэгт заасан мэдээллээс ихэнх байгууллагууд батлагдсан төсвийн хуваарь, сар улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээг өөрийн байгууллагын мэдээллийн самбарт байршуулж байна.

A.3 Нийгмийн даатгалын сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Халамжийн сангийн орлого, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлтийг хагас жил, жилийн эцсийн байдлаар мэдээллийг байршуулаагүй,

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын даргын тушаалаар Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг дэмжих малжуулах чиглэлээр олгосон нийт 16 ажил гүйлгээнд зарцуулсан 854,3 сая төгрөгөөс 12 ажил гүйлгээний 736,5 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй зөрчлийг ирлүүлэн аудитын явцад ХЭДС-гийн шилэн дансны цэст байршуулуулж иргэдийг сонирохсон мэдээллээр нь хангалаа.

¹⁷ байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт;

¹⁷ Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр

¹⁸ Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахам хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байршуулна.

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны 1-4 сар, 6, 9 саруудын ихэнх мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн хэдий ч иргэд олон нийтийн сонирхсон ач холбогдолтой мэдээлэл байхгүй,

Аймгийн Засаг даргын нөөц сан аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагаанд орж мэдээлэгддэг тул цахим цэснээс салгаж харах боломжгүй байна.

Мөн аймгийн Засаг даргын дэргэдэх замын сангийн төсөв, гүйцэтгэл тайлагналыг мэдээлэх цахим хуудас нэгдсэн цахим цэсэнд байхгүй байгааг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5¹⁹ дахь заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна гэж үзлээ.

Хуулийн 6.5.4²⁰-т заасан 24 сумын ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангийн мэдээлэл байршуулалтыг судлан үзэхэд Улсын төсвийн хэтрэлт, хэмнэлт, түүний шалтгаан тайлбар бичвэрийг улирал бүр мэдээлээгүй.

Хуулийн 6.5.5²¹-д заасан аймгийн ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн 1,3,4,8 дугаар саруудын мэдээлэлийг хугацаа хоцроон байршуулжээ.

Мөн хуулийн 6.5.6²²-д заасан төсвийн гүйцэтгэлийн болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайланг мэдээлээгүй байна.

Хуулийн 6.5.7²³-д заасан төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаас, 6.5.8²⁴-д заасан концессын мэдээлэлтэй холбоотой гүйлгээ гараагүй байна.

Хуулийн 6.5.9²⁵, 6.5.10²⁶, 6.5.11²⁷, 6.5.12²⁸-д заасан мэдээллүүдтэй холбоотой шийдвэр, судалгаа орон нутагт хийгдээгүй байна.

Зорилт Б. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө, оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээг хэрэгжүүлсэн 44 аж ахуйн нэгжийн 3 нь буюу 6,8 хувь нь зөвхөн шилэн дансанд өөрийн цэстэй байгаа нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэхь заалтай нийцэхгүй байна.

Б.1 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллагууд орон нутагт байхгүй.

¹⁹ Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 6.1, 6.4-т заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг гаргана:

²⁰ улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр;

²¹ нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүрийн 15-ны өдрийн дотор;

²² төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа жилийн 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор;

²³ төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасны мэдээллийг улирал бүр

²⁴ концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанаас нь хойш долоо хоногийн дотор;

²⁵ концессын гэрээ болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг гэрээ байгуулагдсанаас нь хойш долоо хоногийн дотор;

²⁶ концессын гэрээ байгуулсан тухай бүрд концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг долоо хоногийн дотор;

²⁷ хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны мэдээллийг улирал бүр;

²⁸ улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлттэй уялдуулсан судалгаа, тооцоог улирал бүр

Б.2 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө, оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээг 2018 онд гүйцэтгэсэн “Хэрмээдэй” ХХК багийн засаг дарга нарыг компьютерээр хангах, Тэлмэн сумын сургуулийн хичээлийн Б байрын засвар, “Жавхлант тур” ХХКомпани Шилүүстэй сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга, “Засагтхан констаракшн” ХХК Их-уул сумд баруун чиглэлийн авто замуудын гол зангилаа хяналтын пост, аялал жуулчлалын мэдээллийн цэгийн барилга угсралтын ажлыг тус тус хийсэн бөгөөд шилэн дансанд өөрийн цэстэй боловч хэрэгжүүлсэн ажлуудын төсөвт өртөг, гүйцэтгэл ажлын явц, үе шат, санхүүжилтийн талаар хуульд заасан хугацаанд тодорхой мэдээлээгүй,

2018 онд ажил үйлчилгээ гүйцэтгэсэн Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д хамаарах 44 аж ахуйн нэгж байгууллагуудаас 3 буюу 6,8 хувь нь нэгдсэн цахим хуудсанд өөрийн цэстэй байгаад Төсвийн ерөнхийлөн захирагч анхаарч ажиллах шаардлагатай байна.

Үүнийг шалтгааныг тодруулахад хуулийн энэ ангилалд хамаарах аж ахуйн нэгжүүдийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах, хянах, тогтолцоог орон нутагт зохион байгуулж ажиллаагүй байгаа нь ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 5.1 дэх заалттай нийцэхгүй байгаад зөвлөмж хүргүүлэн ажиллаа.

Б.3 Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр хийсэн аж ахуйн нэгж, компаниуд нэгдсэн цахим хуудсанд хамрагдаагүй байгаа нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх заалттай нийцэхгүй байна.

Тайлант онд Шилэн дансны өөрийн цэстэй 14 ААНБайгууллагаас нэг нь ч мэдээллийн шинэчлэлт хийгээгүй, хувийн 3 цэцэрлэгээс 1 цэцэрлэг нь хуульд заасан мэдээллүүдийг байршуулсан байна.

Зорилт В. Аймгийн Засаг даргад өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

В.1 Шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд шат, шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурал, иргэдийн Нийтийн хурлаас тодорхой хяналт хийсэн судалгаа, ажлын тайлан, дүгнэлт байхгүй байгаа нь хуулийн хуулийн 8 дугаар зүйлийн 8,1 дэх заалтанд нийцэхгүй байна.

2015 оны 4 сараас хойш Үндэсний аудитын газраас ирүүлсэн төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу аймгийн аудитын газар төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд 4 дэх удаагаа аудит хийж дүгнэлт өгсөн байна.

В.2 Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтын хэрэгжилтэд аудит хийхэд аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс болон Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт аудитын албанаас ажлын удирдамж гарган 2017 оны 4 дүгээр улирал, 2018 оны 1, 2, 3 дугаар улиралд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад харьяалагдах байгууллагуудын байршуулсан мэдээлэлд аудит хийж гүйцэтгэсэн байна.

Дээрх 4 удаагийн аудитаар дунджаар 235 нэгж байгууллагуудыг хамруулан хууль, тогтоомжийг хангалтгүй хэрэгжүүлсэн нийт 22 албан тушаалтанд хариуцлага тооцуулан ажиллажээ.

В.3 Хуулийн 8 дугаар зүйлийн 8.4²⁹-д заасан заалтын хэрэгжилт шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.

Тухайлбал: Аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга сумдын ажлыг үнэлж дүгнэх үзүүлэлтийн нэг үзүүлэлтээр тусган 2017 оны жилийн эцсийн шалгаруулалтыг хийсэн, салбар байгууллагууд нь нягтлан бодогчдын ажлыг дүгнэхдээ хуулийн хэрэгжилтийн талаар үзүүлэлт тусгаагүй байна.

Мөн Боловсрол соёл, урлагийн газар, Эрүүл мэндийн салбарын бодлого хариуцсан байгууллагууд харьяа байгууллага, албан тушаалтны ажлыг дүгнэхдээ шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар тусгасан үзүүлэлт байхгүй байна.

В.4 ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөөгөөр 2017 оны 12 сард хийгдсэн нийцлийн аудитаар аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Асгат, Яруу сумдын боловсролын байгууллагын, Алдархаан, Тэлмэн, Отгон сумдын ИТХ, ЗДТГ-ын, Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын, Ойн ангийн, МУИС-ийн Завхан сургуулийн, Отгонтэнгэр рашаан сувиллын, “Очир-Илч” ОНӨААТҮГ-ын нягтлан бодогч нарт, аймгийн ОНХС, Тосонцэнгэл сумын ОНХС хариуцсан мэргэжилтэнүүдэд тус тус хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэн ажилласан.

2018 оны 11 сарын 20-ны байдлаар албан шаардлагын хариуг 9 байгууллага буюу 81,8 хувь нь ирүүлэн, аудитын явцад хэрэгжилтийг шалгахад Улсын бүртгэлийн хэлтэс, Алдархаан, Асгат, Завханмандал сумдын санхүүгийн алба, Тэс, Баянхайрхан, Баянтэс сумдын боловсролын байгууллагын нягтлан бодогчид сайн ажилласан байгааг сайшаах нь зүйтэй.

Өмнөх аудитаар аймгийн Засаг даргад дараах заалт бүхий зөвлөмж өгсөнийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэсэн аж ахуйн нэгж байгууллагуудыг шилэн дансанд өөрийн цахим цэстэй болгох, түүнийг хянах хяналтын тогтолцоог хэрэгжүүлэн ажиллах,
2. Тендер, худалдан авалтын арга хэмжээг зохион байгуулахдаа оролцогч байгууллагууд шилэн дансанд өөрийн цэстэй эсэх, хуулийн дагуу мэдээллээ бүрэн байршуулсан эсэхийг үзүүлэлт болгон оруулах талаар аймгийн Өмчийн алба, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст, үүрэг чиглэл өгч хэрэгжүүлэх,
3. Тухайн аудитын дүгнэлтэд тусгагдсан асуудлуудыг хэрэгжүүлэн, тодорхой ажил зохион байгуулж ажиллах,

²⁹ Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас тавьсан хяналтын тайланг орон нутгийн хэвлэл мэдээлэлд тогтмол байршуулж байх

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

- Шилэн дансны цахим хуудсанд тогтмол байршуулах мэдээллүүдийг хугацаа хоцроон байршуулж байгаа дутагдал дахин давтан гарч байна /Хавсралт судалгааг 3.1.1, 3.1.2 /
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэсэн аж ахуйн нэгж байгууллагуудыг шилэн дансанд өөрийн цахим цэстэй болгох, байршуулсан мэдээллийг хянах, хяналтын тогтолцоог Орон нутагт зохион байгуулаагүй /Хавсралт судалгаа 3.1.3/
- Байгууллагууд өөрийн санхүүжилт, өмч, хөрөнгө, зарцуулах шийвэрийг сар бүр тогтмол мэдээлээгүй. /хавсралт судалгаа 3.1.1, 3.1.2/

Аудитаар нийт 18494.7 сая төгрөгийн зөрчлийг илрүүлээ.

ЗӨВЛӨМЖ

Үндэсний аудитын газраас ирүүлсэн төлөвлөгөө хөтөлбөрийн хүрээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн Засаг дарга Д.Батсайхан-д

1. Нийгмийн даатгалын сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Халамжийн сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлтийг нөхөн байршуулах үүргийг холбогдох албан тушаалтанд өгч хэрэгжилтийг хангуулах,
2. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэсэн аж ахуйн нэгж байгууллагуудыг шилэн дансанд өөрийн цахим цэстэй болгох, байршуулсан мэдээллийг хянах, хяналтын тогтолцоог Орон нутагт зохион байгуулах,
3. Шилэн дансны цахим хуудсанд тогтмол байршуулах мэдээллүүдийг хууль, журмын дагуу мэдээлээгүй аймгийн ИТХурал, аймгийн ОНХСан болон тендерт худалдан авалт хариуцсан мэргэжилтэнүүдийн хариуцлагыг сайжруулах
4. Төрийн аудитын байгууллага, аймгийн Санхүү хяналт, аудитын албанаас хэрэгжүүлсэн хяналтын тайлангуудыг орон нутгийн хэвлэл мэдээлэлд байршуулах ажлыг зохион байгуулах

Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Батмэнд-д

1. Тендер, худалдан авалтын арга хэмжээг зохион байгуулахдаа оролцогч байгууллагууд шилэн дансанд өөрийн цэстэй, хуулийн дагуу мэдээллээ бүрэн байршуулсан эсэхийг сонгон шалгаруулалтын үзүүлэлт болгон оруулах

Нийцлийн аудитаас өгөгдсөн дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэн, биелэлтийг 2019 оны 04-р сарын 15-ны дотор албан тоотоор ирүүлэх.

ДАРГА БӨГӨӨД

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас: 7575-1155, Факс: 7046-2550
И-мэйл: zavkhan.gov.mn@gmail.com

2018.11.30

№

5/1296

танай

-ны №

т

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх шинэчилсэн төлөвлөгөө”-ний дагуу “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлтэй холбоотой саналгүй байна.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА *Ж.ХҮРЭЛБААТАР*



11471

Тоот А5 2018